



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

С.Зоригийн гудамж 2, 1 дүгээр хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976) 7711 1027, Цахим шуудан: info@fchm.edu.mn

2026.05.25 № 1/1113

танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 01/470 тоот албан бичгийн дагуу Эрүүл мэндийн сайдын 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/241 дугаар тушаалаар батлагдсан “Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 2026 оны эхний 05 сарын хэрэгжилтийн тайланг хүргүүлж байна.

Хавсралт 14 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ПАНХТУЯА

141260278

**ХОРТ ХАВДРААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН
УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Төсөв		Хэрэгжилтийн үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төлөвлөсөн өн төсөв в	Зарцуулсан төсөв в эх үүсвэр		
Нэг. Хүн амын дунд хорт хавдрын анхдагч урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг идэвхжүүлэх						
Зорилт Эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах	1.2.	Илүүдэл таргалалтаас нөлөөллийн хэмжээ байгуулах	жин, сэргийлэх арга зохион	Илүүдэл жин, таргалалттай хүн амын хувь	2026 онд УНТЭ-ийн Нийгмийн эрүүл мэндийн алба байгууллагын ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, илүүдэл жин болон зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зөв дадлыг хэвшүүлэх зорилгоор “Өдөр бүр өөрийгөө урлахуй 2” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	90%
	1				Хөтөлбөрт алба, төв, тасгийн 50 гаруй ажилтан хамрагдаж, зөв хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, стресс менежментийн чиглэлээр сургалт, зөвлөгөө авч, биеийн бүтцийн хяналтанд тогтмол хамрагдаж байна. Хөтөлбөрийн үр дүнд оролцогчдын мэдлэг, хандлага, эрүүл зан үйлд эерэг өөрчлөлт гарч, амжилттай оролцсон ажилтнууд илүүдэл жингээ бууруулан эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлсэн. Мөн зарим оролцогч хөтөлбөрөө үргэлжлүүлэн хэрэгжүүлж, цаашид тогтвортой хамрагдан ажиллаж байна.	
2	Бүх төрлийн тамхины үзүүлэх сөрөг нөлөө болон дам	15-69 насны хүн амын дундах			 Зураг 1. Сургалт, хөөлтийн явцаас Жил бүрийн 5 дугаар сарын 31-ний өдрийг Дэлхийн тамхигүй өдөр (Дэлхийн тамхины эсрэг өдөр) болгон тэмдэглэдэг. Тэмдэглэлт өдрөөр	50%

	тамхидалтын бууруулахад мэдээлэл сурталчилгааны хэмжээ байгуулах	тархалтыг чиглэсэн арга зохион	тамхины хэрэглээ 24.2% (STEPS-2019)		удирдамж, төлөвлөгөө боловсруулан нөлөөллийн ажил өрнүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	
3	Зонхилон хорт хавдрын хүчин бууруулах удирдах баталсан жилийн төлөвлөгөөний олон нийтэд мэдээлэл сурталчилгааны зохион байгуулах	тохиолдох эрсдэлт зүйлсийг чиглэлээр хороогоор ажлын дагуу чиглэсэн ажил	Тухай жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны биелэлтийн хувь		УНТЭ-ийн НЭМА, ЦЭСЧШСТ-тэй хамтран хэвтэн эмчлүүлэгчид болон амбулаториор үйлчлүүлж буй ард иргэдэд Хорт хавдраас урьдчилан сэргийлэх тараах материал, гарын авлагыг 100 гаруй үйлчлүүлэгчид тараахаас гадна УНТЭ-ийн Цусны хавдрын талаар нөлөөлөх хүчин зүйл, эрсдэлт бүлэг, зөвлөгөө мэдээлэл олгох үүднээс ярилцлага бэлтгэж, УНТЭ албан ёсны цахим хуудаст мэдээ мэдээлэл бэлтгэн, түгээн байршуулж ажилласан. Хандалтын тоо 13.973 Дэлгэрэнгүй мэдээлэл https://www.unte.moh.gov.mn/a/933 Дэлхийн хавдрын өдөр 2026-02-04 Цусны хорт хавдрыг урьдчилан сэргийлэх боломж хагаарлагдмал байдаг ч эрт илрүүлэх боломжтой. Ингэснээр өвчний хүндрэл, эрсдэлийг бууруулж, эмчилгээний үр дүнг сайжруулах боломж бүрдэнэ.  	80%
Хоёр. Хорт хавдрын оношилгоо, эмчилгээний чадавхыг сайжруулж, орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх						
Зорилт 2.1. Молекул биологи, молекул генетикийн оношилгооны	Шинээр молекул оношилгооны эмч, (лабораторийн техникч, технологийн	нэвтрүүлсэн генетикийн чиглэлээр мэргэжилтнийг эмч, мэдээлэл инженер.	Сургалтад хамрагдсан багийн тоо		ЭЭСНЛ-ийн эд нийцэл, молекул генетикийн хэсгийн 1 эмч 2 лаборантыг NGS library (хорт хавдрын генийн мутаци тодорхойлох) хэрхэн бэлдэх, шинжилгээ яаж явагддаг талаар дотоод сургалтанд хамрагдсан.	90%

чадавхыг сайжруулах	биоинформатикийн ажилтан, техөөрөмжийн багаар нь чадавхжуулах	тоног инженер) сургах, чадавхжуулах				
Зорилт 2.2. Эмгэг судлалын оношилгооны чадавхыг сайжруулж, орчин үеийн дэвшилтэт технологич нэвтрүүлэх	6	Слайд сканнер ашиглан өндөр хөгжилтэй орноос эмгэг судлалын зөвлөн туслах үйлчилгээ авах, зайнаас орон нутагт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх	Алсын зайн зөвлөгөөнөөр шийдсэн шинжилгээний тоо			Слайд сканнерийн зах зээлийн үнэ 500.000.000-2.000.000.000 /таван зуун сая төгрөгөөс хоёр тэрбум төгрөг/-ийн хооронд байгаа учраас эмнэлэг өөрийн нөөц бололцоогоор худалдан авах боломжгүй тул "Зайн оношлогооны чадамжийг дээшүүлэх нь" сэдэвт төсөл боловсруулж байна. Харин өндөр хөгжилтэй орнуудаас зөвлөн туслах үйлчилгээ авах хүрээнд Герман улсын Caseio платформд бүртгэл үүсгэж олон улсын эксперт, доктор, профессор Dietmar Künze эмчээс Olympus BX53 микроскопоор өндөр нягтралтай JPG зураг авч зөвлөгөө авч байна. Одоогийн байдлаар хортой хавдар, ховор тохиолдолд онлайн зөвлөгөө авч байна..
	7	Гистохимийн шинжилгээнд ашиглах будагч бодисын нэр төрлийг нэмэгдүүлэх.	Шинжилгээний нэр төрлийн тоо			Эмнэлзүйн эмгэг судлалын нэгдсэн лаборатори Гистохимийн будаг болон PAS stain, Masson, Silver будагч уусмал ашиглаж 2026 оны 05 сарын байдлаар 80 хүнд ялган оношлогоог хийж сайжруулан ажиллаж байна.
	8	Иммуногистохимийн шинжилгээний чадавхыг сайжруулах, нэр төрлийг нэмэгдүүлэх	Шинжилгээний тоо, маркерийн тоо			2025 оны 07 сарын 20-ны өдөр эмнэлгийн захиргааны дэмжлэгтэй нийт 20.000.000 төгрөгийн өртөг бүхий иммуногистохимийн дагалдах уусмалуудыг хүлээн авсан. 8-10 сарын хооронд туршилтын журмаар будах, үнэлгээ өгөх дадлага хуримтлуулах, арга аргачлал, САЗ боловсруулах, нэмэлт жижиг хэрэгсэлүүдийг бэлтгэх, мөн чанарын хяналт үнэлгээ хийлгэх зэрэг бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэж, эмнэлзүйн хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна.
Зорилт 2.3. Дүрс оношилгооны шинжилгээний хариуг зайнаас цахимаар хянах, үнэлгээ өгөх үйл ажиллагааг нэвтрүүлэх	9	Хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн хавдрын байгууллагууд хавдрын оношилгооны чиглэлээр олон мэргэжилтний зөвлөл байгуулж, эмч, мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх	Шинээр байгуулагдсан олон мэргэжилтний зөвлөл, цахимаар холбогдсон тоо			Монгол улсын эрүүл мэндийн тухай хуулийн 16.16 зүйл, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, " Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого-2017-2026, ЭМС-ын 2016 оны A/29, 2021 оны A/360 тоот тушаалаар батлагдсан "Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөө", хавдрын тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулж хүртээмжийг нэмэгдүүлэх, УНТЭ-т үзүүлж буй хавдрын тусламж үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор, УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2025 оны 11 сарын 11-ний A/333 тоот тушаалаар хавдрын зөвлөл батлагдсан. Хавдрын зөвлөлийн хурлыг сар бүрийн 1 ба 3 дахь долоо хоногийн Пүрэв гаригт 13:00 цагаас "Алсын зайн оношилгооны төв"-д зохион байгуулах ба хурлыг зөвлөлийн дарга удирдан явуулахаар журамд заасан

Зорилт 2.4. Аймаг, нийслэлд хорт хавдрын мэс заслын тусламж, үйлчилгээг нэвтрүүлэх, чадавхжуулах	1 УНТЭ, УХТЭ-т хүзүүний хорт хавдрын мэс заслын тусламж, үйлчилгээг хөгжүүлэх	Хийгдсэн мэс заслын тоо			2026 онд Чих хамар хоолой, мэс заслын тасгийн эмч нар хамтран Хоншоорын хөндийн хавдрын үүсгэгчийг чөлөөт далбангаар тайрах мэс 2, хамрын дайвар хөндий болон хамрын хөндийн хорт хавдрыг дурганаар авах мэс заслыг 2 тохиолдолд , төвөнхийн хорт хавдрын төвөнх бүтэн авах мэс засал-2, төвөнхийн хавдрын дараах нөхөн сэргээх мэс засал-1, Эрүүн доорхи шүлсний булчирхайн хавдар тайрах мэс засал-2 зэрэг мэс заслуудыг хийсэн. Толгой, хүзүүний мэс заслын чиглэлээр эмч 3.Мэндсайхан, Д.Нямсүрэн нар БНСУ болон Хавдар Судлалын Үндэсний Төвд мэргэжил дээшлүүлэн суралцаж байна.	90%
2 Эмнэлзүйн стандартад хими, бай, болон даавар эмийн нэр төрлийг нэмэгдүүлэх		Эмчилгээнд шинээр нэвтрүүлсэн эмийн тоо			NCCN (хорт хавдрын үндэсний нэгдсэн сүлжээ)-ний зөвлөмжийн дагуу уушгины хавдар, давсагны хавдар, хөхний хавдарын хими эмчилгээнд Пеметриксит тариаг 6 удаа хэрэглэсэн. байна.	80%
Зорилт 2.7.Хавдрын системийн эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх	3 Хими судлалын зохион аймаг, хавдрын хими чиглэлээр сургалтад хамруулах	Сургалтад хамрагдсан эмчийн тоо		Гадаад сургалтанд хамрагдсан эмчийн тоо-3	2026 оны 01 дүгээр сарын 26-30-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Турк Улсын "Hisar Hospital" эмнэлэгт Э.Бат-Өлзий, З.Намсрай, Да.Номин эмч нар ажлын байрны гардан сургалтанд амжилттай хамрагдаад ирлээ. Сургалтын үеэр орчин үеийн оношилгоо, эмчилгээний арга технологи, эмнэлзүйн менежмент болон олон улсын сайн туршлагатай танилцаж, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэв.  Зураг 3 . Сургалтын явцаас	90%
					Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн БШГМЗТ-ийн эмч З.Намсрай нь 2026 оны 03 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Франц улсын Парис хотноо зохион	

					байгуулагдсан “ESMO Targeted Anticancer Therapies Congress 2026” олон улсын хуралд оролцсон. Тус хурлын үеэр хавдрын бай эмчилгээ, дархлаа эмчилгээ болон хорт хавдрын эмчилгээний сүүлийн үеийн судалгаа, эмчилгээний шинэ чиг хандлагуудыг хэлэлцэж, олон улсын эмч мэргэжилтнүүдтэй туршлага солилцож, оролцсон мэдлэг, туршлагаа цаашид эмчилгээ, оношилгооны чанар хүртээмжийг сайжруулахад ашиглан ажиллаж байна.	88%
					 Зураг 4. Сургалтын явцаас Гүйцэтгэлийн дундаж хувь	

НЭГ. ЭЛЭГНИЙ ХОРТ ХАВДРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Төсөв		Биелэлт, үр дүн	хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан н төсөв эх үүсвэр (сая,төг)		
1.2. Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх, эрт оношлох үйл ажиллагааг зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа						
4	1.2.1. С илрүүлгийн шинжилгээнд дээш насны, өмнө нь шинжилгээнд хамрагдаж байгаагүй	Гепатитын В, С вирусийн түргэвчилсэн шинжилгээнд хамрагдсан хүн амын эзлэх хувь	-	-	УНТЭ-ийн Эрүүл мэндийг дэмжих төвд нийт 292 хүнд байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэгийн хүрээнд гепатит В, С вирусийн түргэвчилсэн шинжилгээ хийсэн. Үүнээс 28 (9.6%) хүн Гепатит В вирус, 10 (3.4%) хүн Гепатит С вирусээр оношлогдсон. Мөн элэгний зангилаа ≥ 1 см 2 (0.7%) хүн, цусанд АFR ≥ 10 ng/ml 2 (0.7%) хүн илэрсэн ба элэгний цирроз 3 (1.0%) тохиолдол бүртгэгдсэн. Өөрчлөлттэй тохиолдлуудад шаардлагатай зөвлөгөө өгч, хяналт болон цаашдын шинжилгээний зөвлөмжийг хүргүүлсэн.	70%

	иргэдээс хамруулж, эхлэн хорт хавдрын эрт илрүүлгийн зорилтот бүлгийн хүн амыг тодорхойлох						
5	1.2.2. Зорилтот бүлгийн хүн амыг эрт хавдрын эрт илрүүлэгт алгоритмийн дагуу хамруулах	Зорилтот бүлгийн хүн амын эрт илрүүлэгт хамрагдсан хувь				2026 оны 5 сарын байдлаар Эрүүл мэндийг дэмжих төвд элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн алгоритмын дагуу зорилтот бүлгийн хүн амыг системтэйгээр хамруулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 292 хүн хамрагдсан бөгөөд гепатит В, С вирус, элэгний зангилаа, АFR, циррозын үзүүлэлтүүдийг алгоритмын дагуу үнэлж, өөрчлөлттэй тохиолдлуудад шаардлагатай зөвлөгөө өгч, хяналт болон цаашдын шинжилгээний зөвлөмжийг хүргүүлсэн.	70%
	1.2.7. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт эргэн дуудах системийг хөгжүүлж, тогтолцоог бүрдүүлэх	Эрт илрүүлэг эргэн дуудах тогтолцооны программд мэдээний сан үүсгэсэн байгууллагын эзлэх хувь				2026 оны 5 сарын байдлаар Эрүүл мэндийг дэмжих төвд элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн дуудах, эргэн дуудах системийг хөгжүүлж, байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн. Системийн хүрээнд нийт 292 зорилтот бүлгийн хүн амыг бүртгэн гепатит В, С вирусийн шинжилгээ, элэгний зангилаа, цусны АFR болон циррозын үзүүлэлтийг үнэлж, өөрчлөлттэй тохиолдлуудад шаардлагатай зөвлөгөө өгч, хяналт болон цаашдын шинжилгээний зөвлөмжийг хүргүүлсэн.	70%
1.3.Элэгний хорт хавдрын оношилгоо, эмчилгээний чадавхыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа							
	1.3.2. Эрт илрүүлгээр оношлогдсон Гепатит В, С вирус тээгч хянах, тогтолцоог бүрдүүлж, хамрагдахыг сайжруулах	Тухайн жилийн зорилтот хүн амын эмчилгээнд хамрагдсан хүний эзлэх хувь				Эрүүл мэндийг дэмжих төвд 2026 оны 5 сарын байдлаар урьдчилан сэргийлэх үзлэгээр оношлогдсон Гепатит В, С вирус тээгч иргэдэд эмчилгээ, хяналтын тогтолцоог бүрдүүлсэн. Өөрчлөлттэй иргэдэд лабораторийн шинжилгээ, даван хяналтын үзлэгийн хуваарь, шаардлагатай эмчилгээний зөвлөмжийг алгоритмын дагуу өгч, тухайн хүмүүсийн хамрагдалт, эрүүл мэндийн байдал тогтмол хяналтад авсан.	70%
			Гүйцэтгэлийн дундаж хувь				
			70%				

ХОЁР. УЛААН ХООЛОЙ, ХОДООД, БУДУУН-ШУЛУУН ГЭДЭСНИЙ ХОРТ ХАВДРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр		
2.2. Улаан хоолой, ходоод, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрыг эрт илрүүлэх, эрт оношлох үйл ажиллагааг зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө						
1	2.2.1. Ходоод, улаан хоолойн хорт хавдрын эрт илрүүлэгт 40-с дээш насны иргэдийг хамруулах	Тухайн жилийн зорилтот бүлгийн хүн амын эрт илрүүлэгт хамрагдсан хувь	-	-	2026 оны 5 сарын байдлаар Эрүүл мэндийг дэмжих төвд нийт 134 ходоод, улаан хоолойн дурангийн шинжилгээ хийгдсэн. Үүнээс 112 (83.6%) нь хэвийн буюу өнгөц үрэвсэлтэй, 13 (9.7%) нь ходоодны архаг явцтай идэвхтэй үрэвсэл болон шарх/шархлааны өөрчлөлттэй, 4 (3.0%) нь ходоодыг нэлэнхүйд хамарсан архаг идэвхтэй үрэвсэл, 4 (3.0%) нь ходоодны их биеийг хамарсан хатингаршил болон гэдэсжих метаплази илэрсэн байна. Мөн 1 (0.7%) тохиолдолд эдийн шинжилгээ авч, хорт хавдрыг үгүйсгэсэн. Өөрчлөлттэй тохиолдлуудад шаардлагатай зөвлөгөө өгч, цаашдын хяналт болон нэмэлт шинжилгээний зөвлөмжийг хүргүүлэн хяналтад авсан.	80%
2	2.2.2. Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэгт 45-аас дээш насны иргэдийг хамруулах	Тухайн жилийн зорилтот бүлгийн хүн амын эрт илрүүлэгт хамрагдсан хувь			2026 оны 5 сарын байдлаар Эрүүл мэндийг дэмжих төвд нийт 78 бүдүүн шулуун гэдэсний дурангийн шинжилгээ хийгдсэн. Үүнээс 73 (93.6%) нь ямар нэг өөрчлөлтгүй, 5 (6.4%) нь бага эрсдэлтэй өөрчлөлттэй гэж үнэлэгдсэн. Өөрчлөлттэй илэрсэн иргэдэд шаардлагатай зөвлөгөө өгч, хяналт болон нэмэлт шинжилгээний зөвлөмжийг хүргүүлсэн.	80%
3	2.2.8. Улаан хоолой, ходоод, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэгт дуудах, эргэн дуудах системийг хөгжүүлж, тогтолцоог бүрдүүлэх	Системийн хөгжүүлэлт, системийг ашиглах чадамж бүхий эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь			2026 оны 5 сарын байдлаар Эрүүл мэндийг дэмжих төвд улаан хоолой, ходоод, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлгийн дуудах, эргэн дуудах системийг хөгжүүлж, ашиглах чадамжийг бүрдүүлэн үйл ажиллагаанд нэвтрүүлэв. Системийн хүрээнд нийт 134 ходоод, улаан хоолойн дуран, 78 бүдүүн шулуун гэдэсний дурангийн шинжилгээг хийж, нийт 212 иргэнийг эрт илрүүлэгт хамруулав. Ходоод, улаан хоолойн дурангаар 112 нь хэвийн буюу өнгөц үрэвсэлтэй, 21 нь архаг үрэвсэл, шарх, шархлаа, метаплазийн өөрчлөлттэй, 1 тохиолдолд эдийн шинжилгээ авч хорт хавдрыг үгүйсгэн хяналтад авсан. Бүдүүн шулуун гэдэсний дурангийн 78 тохиолдлоос 73 нь өөрчлөлтгүй, 5 нь бага эрсдэлтэй өөрчлөлттэй гэж үнэлэгдсэн. Эрт илрүүлгийн бүх өөрчлөлттэй тохиолдлуудад зөвлөгөө өгч, нэмэлт шинжилгээний зөвлөмжийг хүргэсэн.	80%

2.4.Ходоодны хорт хавдрын эмнэлгийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.4.6 .УНТЭ, УХТЭ, Увс НЭ-т ходоодны хорт хавдрын эрт үед салст хуулах мэс засал эмчилгээг хөгжүүлэх	Шинээр мэс засал хийх чадамж бүхий ЭМБ-ын тоо			УНТЭ нь “Дурангийн онош зүйн “ 6 сарын мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах эрхтэй бөгөөд орон нутаг болон дүүргүүдийн эмнэлгүүдийн дурангийн 10 гаруй эмчид уг сургалтанд хамруулсан. Тус сургалтын хөтөлбөрт “Ходоодны хорт хавдрын эрт үед салст хуулах мэс засал эмчилгээ” - ний талаар оруулсан.	90%
2.4.7. Дурангийн эмч нарыг ходоодны хорт хавдрын салст хуулах мэс засалд сургах	Сургагдсан эмч, мэргэжилтний тоо			2026 оны байдлаар УНТЭ-ийн Гастроэнтерологийн төв нь дурангийн нарийн мэргэжлээр 1 эмчийг бэлтгэж, мөн 1 эмчийг ходоодны хорт хавдрын салст хуулах мэс заслын (ESD) техник эзэмшүүлэх сургалтад хамруулан сургаж байна.	90%
				Гүйцэтгэлийн дундаж хувь	84%

ГУРАВ. УУШГИНЫ ХОРТ ХАВДРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжи л--тийн хувь
			Нийт төлөвлөсө н төсөв	Зарцуулса н төсөв эх үүсвэр (сая, төг)		
3.2. Уушгины хорт хавдрыг эрт илрүүлэх, эрт оношлох үйл ажиллагааг зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа						
1	3.2.1. Уушгины хорт хавдрын эрт илрүүлэгт зорилтот бүлэг (50-аас насны, 15-аас жил тамхи хүйн хамруулах	Зорилтот бүлгийн амын илрүүлэгт хамрагдсан хувь	хүн эрт		2026 онд УНТЭ-ийн амбулаторийн тасгийн уушгины кабинетаар үйлчлүүлсэн иргэдээс 57-76 насны 22 хүн уушгины хорт хавдараар сэжиглэж буйг илрүүлэн, хяналт болон нэмэлт шинжилгээ болох уян дурангаар эд авч, гуурсан хоолойн уян дурангаар эд авах EBUS-TBNA, EBUS-TBLB оношилгоо шинжилгээгээр баталж ажиллаж байна.	80%
					Гүйцэтгэлийн дундаж хувь	80%

ДӨРӨВ. УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр (сая, төг)		
4.2. Умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх, эрт оношлох үйл ажиллагааг зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа						
1	4.2.1. Умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх шинжилгээнд зорилтот бүлгийн (эсийн шинжилгээ 27 нас, 45-63 нас, ПГУ шинжилгээ 30 ба 40 нас) эмэгтэйчүүдийг хамруулах	Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн эрт илрүүлэгт хамрагдсан хувь			2026 оны 5 сарын байдлаар байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан нийт 12 эмэгтэйдээс умайн хүзүүний эсийн шинжилгээ (Pap smear) өгсөн бөгөөд дараах үр дүн гарсан байна: • ASC-H – 0 тохиолдол (Atypical Squamous Cells – cannot exclude HSIL) Хэвийн бус хавтгай эсүүд илэрсэн бөгөөд хүнд зэргийн эсийн өөрчлөлт (HSIL)-ийг үгүйсгэх боломжгүй гэж үнэлэгдсэн. • LSIL – 0 тохиолдол (Low-grade Squamous Intraepithelial Lesion) Хөнгөн зэргийн хавтгай эсийн өөрчлөлт илэрсэн, ихэвчлэн HPV-н нөлөөгөөр үүсдэг хөнгөн хэлбэрийн өөрчлөлт. • ASC-US – 2 тохиолдол (Atypical Squamous Cells of Undetermined Significance) Хэвийн бус эсүүд илэрсэн ч өөрчлөлтийн шалтгаан тодорхойгүй, хөнгөн зэргийн өөрчлөлттэй байх магадлалтай. • HSIL – 0 тохиолдол (High-grade Squamous Intraepithelial Lesion) Умайн хүзүүний хавтгай эсүүдэд хүнд зэргийн эсийн өөрчлөлт илэрсэн. Энэ нь хавдрын өмнөх шат байх магадлалтай тул нарийвчилсан шинжилгээ (колпоскопи, биопси) шаардлагатай гэж үнэлдэг.	80%


2	4.2.6. Умайн хорт хавдрын эрт илрүүлэгт дуудах, эргэн дуудах, хөгжүүлэх, бүрдүүлэх	Системийн хөгжүүлэлт, системийг ашиглах чадамж бүхий эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь				• Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт хамруулах зорилгоор байгууллагын зорилтот насны эмэгтэйчүүдийн бүртгэлийг шинэчлэсэн. • Дуудах болон эргэн дуудах ажлыг зохицуулах суурь мэдээллийн сан бүрдүүлж, давтамжтай хяналт хийх боломжийг бий болгосон. • Хамрагдаагүй болон дахин ирэх шаардлагатай иргэдийн жагсаалтыг гарган, утсаар болон мессежээр анхны дуудлага, эргэн дуудлага. • Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 12 эмэгтэйн мэдээллийг системд бүртгэн, эрсдэлийн бүлгээр нь ангилан хяналт хийх механизм бүрдүүлсэн. • Эсийн шинжилгээний хариунд үндэслэн ASC-US гарсан иргэдэд зориулсан дараагийн шатны үзлэгт (колпоскопи, давтан шинжилгээ) илгээх эргэн дуудлагын ажлыг зохион байгуулсан. • Эрт илрүүлэгт хамрагдах иргэдийн бүртгэл шинэчлэгдсэнээр хяналтын чанар сайжирч, дуудлагын хүртээмж 80–95% болсон. Эрт илрүүлэгт хамрагдсан нийт 12 эмэгтэйн эсийн шинжилгээ амжилттай хийгдэж, эрсдэлийн бүлгийн ангилал • ASC-H – 0 тохиолдол • LSIL – 0 тохиолдол • ASC-US – 2 тохиолдол • HSIL – 0 тохиолдол • Эрсдэлт өөрчлөлттэй гарсан иргэдийг дараагийн шатны тусламж үйлчилгээ рүү илгээх эргэн дуудлагын тогтолцоо хэвшиж, хяналтаас хоцрох тохиолдол буурсан. • Байгууллагын хэмжээнд умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийг эрт илрүүлэх, эрсдэлийн түвшинг бууруулах системийн үндэс бүрдэж, урьдчилан сэргийлэх ажлын чанар сайжрав.	80%
						Гүйцэтгэлийн дундаж хувь	80%

ТАВ. ХӨХНИЙ ХОРТ ХАВДРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэг жил тийн хувь
		Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр (сая, төг)		
5.2. Хөхний хорт хавдрыг эрт илрүүлэх, эрт оношлох үйл ажиллагааг зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа					
1	5.2.1.Хөхний хавдрын эрт илрүүлэгт 40-с дээш насны эмэгтэйчүүдийг хамруулах	Зорилтот бүлгийн хүн амын эрт илрүүлэгт хамрагдсан хувь	-	2026 оны 5 сарын байдлаар байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэгийн хүрээнд нийт 88 эмэгтэйд хөхний эхо шинжилгээ хийлгэхэд ихэнх нь хэвийн буюу BI-RADS 1 (85.2%) ангилалд багтаж байна. BI-RADS 2 ангилалд 10 тохиолдол (11.4%) бүртгэгдсэн бөгөөд эдгээр нь сайн чанарын өөрчлөлттэй байсан. Харин BI-RADS 3 ангилалд нийт 3 тохиолдол (3.4%) илэрсэн ба эдгээр тохиолдолд 6 сарын дараах хяналтын УЗИ шинжилгээнд давтан хамрагдахыг зөвлөсөн	80%
2	5.2.5. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт дуудах, эргэн дуудах системийг хөгжүүлж, тогтолцоог бүрдүүлэх	Системийн хөгжүүлэлт, системийг ашиглах чадамж бүхий эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь		Нийт 88 эмэгтэйг эмнэлгийн дотоод сүлжээнд бүртгэн хөхний эхо шинжилгээгээр ангилан хяналт хийсэн. BI-RADS 2 болон 3 зэрэг өөрчлөлт илэрсэн иргэдэд давтан хяналт хийх болон маммографи шинжилгээ өгөхийг зөвлөсөн. Эргэн дуудах системийн хөгжүүлэлт УНТЭ-т хэрэгжээгүй , хавдар судлалын үндэсний төвийн хорт хавдар илрүүлэг тандалтын албанаас тордуулахад улсын хэмжээнд системийн хөгжүүлэлт зөвхөн хавдар судлаын үндэсний төвд байгаа 2026 оноос бусад эмнэлгүүдэд хэрэгжиж эхлэх төлөвлөгөөтэй байгаа хэдий ч манай эмнэлэг нь хөхний хавдарын шинж илэрсэн BI-RADS 2 ангилалд 10 тохиолдол BI-RADS 3 ангилалд нийт 3 тохиолдолд хавдар судлалын үндэсний төвд хандан дааргийн шатны шинжилгээнд хамрагдахыг зөвлөсөн.	80%
				Гүйцэтгэлийн дундаж хувь	80%

ЗУРГАА. ЦУСНЫ ХОРТ ХАВДРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэг жил тийн хувь
			Нийт	Зарцуулсан төсөв эх үүсвэр		
6.1.Цусны хорт хавдрын оношилгоо, эмчилгээний чадварыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа						
1	6.1.1. Цусны үүдэл эс шилжүүлэн суулгах чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах	Шинээр бэлтгэгдсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	-	-	1. Эмч Б.Анударь нь цусны нарийн мэргэжлийн эмчээр бэлтгэгдэж байна. 2. Цусны салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, хэт төвлөрлийг бууруулах зорилгоор Япон–Монголын эмнэлгийн хамтын ажиллагааны хүрээнд 2 эмчийг 6 сарын хугацаатай цусны эмчийн мэргэжил олгох клиникийн дагалдан сургалтад хамруулан сургалцаж байна.	80%
2	6.1.2. Цусны хавдрын оношилгоо, эмчилгээний удирдамжийг боловсруулж, батлуулах	Шинээр батлагдсан оношилгоо, эмчилгээний заавар-1			Цусны эмгэг судлал, чөмөг шилжүүлэн суулгах төвөөс дараах 3 эмгэгийн оношилгоо, эмчилгээний зааврыг бүрэн шинэчлэн боловсруулж, журмын дагуу хэлэлцүүлэн Эрүүл мэндийн яаманд хүргүүлээд байна. Үүнд: • Цусны миелоид эсийн хурц хавдар • Цусны лимфоид эсийн цочмог хавдар • Цусны плазмоцит эсийн хавдар /Миеломын эмгэг/ одоогоор батлуулах шатанд хүлээгдэж байна	90%
3	6.1.3. Цусны хавдрын оношилгоо, эмчилгээний чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд чадавхжуулах сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан эмчийн тоо			Төрийн Тусгай Албан Хаагчдын Нэгдсэн Эмнэлэгийн эмч нарт Т-эсийн лимфомын оношилгоо эмчилгээний талаар сургалт хийсэн. Нийслэлийн Эрүүл мэндийн гадын харьяа Энэрэл эмнэлэгт цусны хадарын оношилгоо эмчилгээний талаарх сургалт эрхion байгуулав.	90%
4	6.1.4. Цусны эсийн дархлаа эмчилгээ, CAR-T эмчилгээг шинээр нэвтрүүлэх	Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний арга			 Зураг 5 . Сургалтын явцаас CAR-T эмчилгээг шинээр нэвтрүүлэх төсөл бичгдаж дууссан. ШУТС болон бусад хамтран ажиллах дэмжих байгууллагад танилцуулга хийж байгаа Эсийн дархлааны NK, T, DC эсээр хавдрын эсийн дархлаа эмчилгээг 9 хүнд хийж байна.	80%



Зураг 5 . Сургалтын явцаас

[illegible]

					хавдартай, өндөр настай-1 тохиолдлуудад нийт 720 гаруй сая төгрөгийн Акалабрутиниб эмийг 30%-г өвчтөн төлөх нөхцөлтэйгээр тусламжаар авч уулгаж байна.	
6.2. Цусны хорт хавдрын эмч нарыг чадавхжуулах, зайн оношилгоог өргөжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа						
9	6.2.1.Цус эмчийн баримжаа сургалтыг аймаг, дотрын эмч нарт байгуулах	судлаач олгох нийслэлийн зохион баримжаа сургалтыг аймаг, дотрын эмч нарт байгуулах	Сургалтад хамрагдсан эмчийн тоо	 	Төрийн Тусгай Албан Хаагчдын Нэгдсэн Эмнэлэгийн эмч нарт Т-эсийн лимфомын оношилгоо эмчилгээний талаар сургалт хийсэн. Нийслэлийн Эрүүл мэндийн гадын харьяа Энэрэл эмнэлэгт цусны хадарын оношилгоо эмчилгээний талаарх сургалт зрхион байгуулав.	70%
10	6.2.2. Цахимаар үнэлэх, зөвлөгөө өгөх "Цахим эмч" хөтөлбөрийг нийслэл, орон нутагт хэрэгжүүлэх	Цахимаар өвлөгөө авсан эмчлүүлэгчийн тоо Цахимаар олбогдсон ЭМБ-ын тоо	ЭМЯ-с зохион байгуулсан ХУД-т онлайн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд цусны эмч нийт 14 хүнд онлайн зөвлөгөө өгсөн Хөдөө орон нутаг болон Улаанбаатар хотын бусад эмнэлгүүдээс цусны эмчид хүн үзүүлэхээр ирсэн дуудлагуудаас – 22 тохиолдолд онлайн зөвлөгөө өгсөн /Утсаар болон wiber, Telegramm, E mail –р үзлэг зөвлөгөөг илгээсэн/	Зураг 7. Сургалтын явцаас		70%
				Гүйцэтгэлийн дундаж хувь		77%

ХЯНАСАН:
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБАНЫ ДАРГА

Г.АЛТАНЦОО

БОЛОВСРУУЛСАН:
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.ГАНДУЛАМ